"МНТ"-НЫ "sirqa aqta-tan" ХЭМЭЭХ ҮГ ХИЙГЭЭД ДУНДАД ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ "-tan" ДАГАВРЫН СУДАЛГАА

Ш.Чоймаа (Монгол)

"МНТ"-нд 12 удаа гарах "sirqa aqta-tan" [шарга агтан] хэмээх үг ямар ямар үгтэй холбогдож, аль хэргийн учрыг өгүүлэхэд тохиолдов гэдгийг эх галигаас эшлэн, бас Лу "Алтан товч"-ийн тохиролцох хэсгийг хамт сийрүүлэн үзье.

1. **МНТ** &77 "...bekter hulqun de'ere sirqa aqta-tan yisün mori[t] qaraǰu sa'u büküi-tür..." (1-29) [Бэгтэр улхан (довцог) дээр шарга агтан есөн морьдоо харж суун бүхүйд...]
   ЛАТ[*] "begter ulqun degere siraγ-a aγta-tan yisün morid-iyan qaraǰu saγun aǰuγu" (2-17b)
2. **МНТ** &90 "niken üdür sirqa aqta-tan naiman mori[t] ger-ün dergede bayiǰu büküi-yi..." (1-34) [нэгэн өдөр шарга агтан найман морьд гэрийн дэргэд байж бүхүйг...]
   ЛАТ "nigen edür sirγa aγta naiman morid ger-ün dergede bayiǰu büküi-tür..." (2-20b)
3. **МНТ** &90 "...sirqa aqta-tan-i de'erme a[b]cu otba kē'esü..." (1-34) [...шарга агтаныг дээрэм авч одов хэмээвээс...]
   ЛАТ "...sirγ-a aγta bidan-i de'erme a[b]cu odba kemebesü..." (2-21a)
4. **МНТ** &90 "...dargi qongqor-i temüǰin unuǰu sirqa aqta-tan-i ebesün-ü alurqai-bar möčgiǰü ..." (1-34) [...дарги хонгорыг Тэмүжин унаж, шарга агтаныг өвсний налирхайгаар мөшгиж...]
   ЛАТ "...tömüǰin dargi qongγur-i unuǰu sirγ-a aγta-tan-i ebesün-i nalurqai-bar mösgiǰü ..." (2-21a)
5. **МНТ** &90 "...sirqa aqta-tan-i surabasu..." (1-34) [...шарга агтаныг сурваас...]
   ЛАТ "...sirγ-a aγta-tan-i surabasu..." (2-21a)
6. **МНТ** &90 "...ene manaqar naran urququ-yin urida sirqa aqta-tan naiman mori[t] e'über hü[l]deǰü yorciba..." (1-34, 35) [энэ манагар (өглөө) наран ургахын урьд шарга агтан найман морьд үүгээр үлдэж зорчив]

---

[*] Лувсанданзаны *"Алтан товч"*-ийг "ЛАТ" гэж тэмдэглэв.

	ЛАТ	"...ene manaγar naran γarqu-yin urida sirγ-a aγta-tan naiman morid-i egüber ü[l]dejü jorciba..." (2-21a)
7.	**МНТ** &90	"...sirqa a[q]ta-tan-u mör-iyer inu möčgijü ..." (1-35) [...шарга агттаны мөрөөр нь мөшгиж...]
	ЛАТ	"...sirγ-a aγta-tan-i mör-iyer mösgijü..." (2-21a)
8.	**МНТ** &90	"...sirqa aqta-tan naiman mori[t] tere yeke güri'en-ü kija'ar-a ebesülen bayiju büküi-yi..." (1-35) [шарга агттан найман морьд тэр их хүрээний хязгаараа өвслөн байж бүхүйг...]
	ЛАТ	"...sirγ-a aγta anu tere küriy-e-ü kijaγar-a ebesün idejü bayiqu-yi..." (2-21a)
9.	**МНТ** &90	"...bi sirqa aqta-tan tede bui hü[l]dejü qarsuqai ke'eba" (1-35) [би, шарга агттан тэд буй, үлдэж гарсугай хэмээв]
	ЛАТ	"...sirγ-a aγta man-u tere bui. bi oruju ü[l]dejü γarγasuγai..." (2-21b)
10.	**МНТ** &90	"...qamtu do[b]tulju oro'a[t] sirqa aqta-tan-i hü[l]dejü qarba" (1-35) [Хамт довтолж ороод, шарга агттаныг үлдэж гарав]
	ЛАТ	"...qamtu dobtulju oruγad sirγ-a aγta-tan-i ü[l]dejü γarbai" (2-21b)
11.	**МНТ** &205	"...basa cinggis-qahan bo'orcu-da ügülerün ücügen caq-tur sirqa aqta-tan naiman morit de'ermettejü ja'ura qurban qonoju nekejü ayisuqui-tur jolqalduba-je ci" (1-116) [Бас Чингис хаан Боорчид өгүүлрүүн: "Өчүүхэн цагт шарга агттан найман морьд дээрэмтэж (дээрэмдэгдэж) зуур гурван хонож, нэхэж айсухуйд золголдов зээ, чи]
	ЛАТ	* ---------- * ---------- * ----------● --- * ---------
12.	**МНТ** &205	"...basa qurban qonoq nekejü sirqa aqta-tan-i de'ermedüksen güri'en-tür gürü'esü..." (1-117) [...бас гурван хоног нэхэж шарга агттаныг дээрэмдсэн хүрээнд хүрвээс...]
	ЛАТ	* ---------- * ---------- * ---------- * ---------

Өмнө толилуулсан "МНТ"-ны "шарга агттан" хэмээх үгийг агуулсан эхний жишээ нь Тэмүжин Хасар хоёр Бэгтэрийг хөнөөх үеийн дүр байдал бөгөөд дараах 9 жишээ бол "шарга агттан найман морьд"-оо дээрэмчинд алдаж, Тэмүжин нэхэн одох зуураа Боорчитой учран, түүний үнэнч тус дэмээр морьдоо эгүүлэн авчирсан зэргийн учир шалтгааныг өгүүлэхэд холбогдож, сүүлчийн хоёр нь Чингис хаан эсгий туургатныг нэгтгэн, Их Монгол улс байгуулсан 1206 онд Боорчийг баруун гарын түмний захирагч болгохдоо гавъяа зүтгэлийг нь тоочиж, анх нөхөрлөсөн үеэ дурсан хэлсэн хэсэгт тохиолдож байна. Ер нь монголын түүх, уран зохиолын дурсгалт бичгүүдэд Боорчийн Тэмүжинтэй нөхөрлөсөн түүхийг

---

* МНТ-ны 176-р зүйлийн эхнээс 208-р зүйлийн эхэн хүртэлх хэсгийг Лу "Алтан товч"-д орхисон тул 205-р зүйлийн сүүлийн хоёр жишээ ЛАТ-д байхгүй.

өгүүлэх бүр "шарга агттан найман морьд"-ын тухай гардаг билээ. Тухайлбал: "Алтан ордны тайллагын "Чингис хааны их өчиг"-т "Нарны гилда (орой) болсонд, найман шарга агтыг чинь, хулгай дээрэм авсан учирт, буянт эзэн биеэрээ дарангатан нэхэж, дарги хонгор морио унаж, давтмал болдоо бөгтөрч, Хөх нуурын тэргэл дээр нөхцөн тус болсон Наху баяны хөвгүүн хүлэг Боорчи..." (3-255, 256) гэж бичсэн байдаг.

Сурвалж бичгүүдийн баримтыг харгуулан нягталбал, Тэмүжиний "шарга агттан найман морьд"-ыг дээрэмчин авч одсон хэрэг 1178 оны шар нохой жилийн зун Сэнгүр горхины Хар Зүрхэний Хөх нуурт нутаглаж байх үест болжээ. 17 настай Тэмүжин хүү "шарга агттан найман морьд"-оо мөшгин нэхэх замдаа Наху баяны хүү Боорчитой учирч, түүний тусламжаар морьдоо олж ирсэн тэр цагаас, тэдний насан туршийн шударга үнэнч нөхөрлөл эхэлсэн түүхтэй билээ.

Тэмүжиний бага насанд учирсан энэхүү үнэн түүхт үйл хэргийг бараг бүх л сурвалж бичигт дурдан тэмдэглэсэн байх ажээ. Гэхдээ зарим сурвалж, Рашид-ад-дины "Судрын чуулган"-д "Чингис хаан бага залуу байхад нь түүний бараа бологчид, цэргүүд нь түүнээс зайлж одсон тул түүнд туслах хүнгүй болжээ. Гэтэл нэг өдөр монгол аймгуудаас дээрэмчид ирж, түүний морьдыг нь хөөгөөд явчихжээ..." (4-118) гэж тэмдэглэсэн шиг ямар зүсмийн хэдэн морь дээрэмдсэнийг тодорхой дурдаагүй байна.

Тухайн үйл хэргийг бус зөвхөн "шарга агттан найман морьд" гэснийг хэрхэн тэмдэглэснээр хөөн дурдвал, "Хураангуй алтан товч"-д "найман шарга", Саган сэцэний "Эрдэнийн товч"-д "найман шарга агтас", Жамбын "Асрагч нэртийн түүх"-д "найман шарга морь", Мэргэн гэгээний "Алтан товч" болон Жамбадоржийн "Болор толь"-д "найман шарга адуун", Инжаннашийн "Хөх судар"-т "эзний эмээлийн найман шар агт эрдэнийн морь" гэх мэтээр ташаа бичиж иржээ.

Лувсанданзаны "Алтан товч"-д ч мөн адил, ихэнхдээ "МНТ"-ны эх болсон судрыг дагуулан хуулсан боловч, дундад үеийн монгол хэлний товчлон хураах бас хүндэтгэх утгат "-tan" дагаврын утга учир, 17-р зууны бичгийн хүмүүст төдий л ойлгомжгүй байсан нь өмнөх МНТ-оос эшлэсэн жишээнүүдтэй зэрэгцүүлэн сийрүүлсэн галигаас харагдаж байна. Лу "Алтан товч"-д байх "Гурван зуун тайчуудыг дарсан домог" зэрэгт Чингис хаан Боорчийг магтан өгүүлсэнийг "Найман шарга морийг нэхэхэд, нарныг гилтэсхийж гарах цагт учирч, насан бүр хүчээ өгсөн, Наху баяны хөвгүүн сайн хүлэг Боорчи минь" (2-49а, 71а) гэж тэмдэглэсэн нь тухайн хэсгийг хожмын судар бичиг, аман домгоос авсныг гэрчилнэ.

Лавтай мэдэгдэж байхаар, 17-р зууны эхэн үеэс өнөө цагийн түүх, уран зохиол хүртэлх олон зууны бичиг, зохиолын арвин сан хөмрөгийн зүйлд МНТ-ны "шарга агттан найман морьд" гэсэн үг хэллэгийг "найман шарга морь" болгон ташаа бичиж, домгийн шинжтэй болгосныг энэ өгүүлэлд шинжлэхийг хичээв.

Судлаачид хэрхэн хөрвүүлж, орчуулав?

МНТ-ны эх галигт байх "sirqa aqta-tan naiman mori[t]" гэсэн хам хэллэгийг эрдэмтэн судлаачид орчин цагийн монгол хэл, уйгуржин монгол бичигт хэрхэн хөрвүүлснийг ажиглахад, Баргын Цэнд гүн, Баяр, Элдэндэй Ардаажав, Ихмянгадай Иринчин, Ш.Гаадамба, Б.Сумъяабаатар, Д.Цэрэнсодном нар эх галигийг баримтлан "шарга агттан найман морьд" гэж буулгасан бол академич Ц.Дамдинсүрэн, Тайчуудай Мансан нар "найман шарга агт" гэж хожуу үеийн сурвалж бичгүүдийг даган хөрвүүлжээ. Эдгээр эрдэмтэн судлаачид ямар нэг тайлбар зүүлт хийгээгүй байна.

Бидний онцлон мөшгиж буй "шарга агттан найман морьд" гэдгийг харь хэлээр орчуулсан эрдэмтдийн орчуулгыг хоёр хуваан үзэж болно.

1. "Шарга агттан" гэдгийг "найман морьд"-ын ерийн тодотгол хэмээн үзэж, С.А.Козин оросоор "восемь соловых меринов" (5-29), Ф.В.Кливез англиар "the eight horses, the isabella geldings" (6-29), П.Пеллио францаар "huit chevaux hongres isabella" (7-140), М.Таубе германаар "die acht Pferde, die isabellfarbenen wallache" (8-32) гэж орчуулсан байх ба бүгд л "найман шарга морь (агт)" гэсэн утгатай ажээ. Эдгээр эрдэмтдийн дотроос П.Пеллио "МНТ"-ны 77-р зүйлд гардаг "шарга агттан есөн морьд" гэдгийг "neuf chevaux hongres isabella" (7-135) (есөн шарга морь) гэж орчуулаад, зүүлтдээ "МНТ"-ны 90-р зүйлд найман шарга морьд дээр оготор хонгор морь нэмэгдээд ес болж байгаа хийгээд 99-р зүйлд зүгээр л есөн морины тоо байгааг ажиглаж, эргэлзэн тэмдэглэжээ (7-135).

2. Нөгөө хэсэг эрдэмтэн судлаач "шарга агттан" гэдгийн "-tan" дагаврын утга, үүргийг анхаарч орчуулсан байна. Үүнд, 14-р зууны сүүл үе буюу Мин улсын эхэн үед уйгуржин монгол эхийг хятадаар галиглаж, үг бүрийн ард хадсан хадмал орчуулга орно. Түүндд "sirqa aqta-tan" гэдгийг " 慘白馬扁馬等 " (9-190) [cǎnbāi shānmǎ děng] хэмээн орчуулсан байх бөгөөд үгчлэн буулгавал, "бүдэг (саарал зүстэй) агталсан морь зэрэг" (10-137, 1363, 302) гэсэн утгатай ажээ. Харин зүйл хэсгийн хойнох утгачилсан хятад орчуулгад děng (зэрэг, -нар, тэргүүтэн) гэдгээ товчилчихсон газар байх юм.

Ахмет Темир туркээр "benekli beyigirle sekiz at" [толбот буурал агт лугаа найман морь], "benekli beyigirle birlikte sekiz at" [толбот агт лугаа цуг найман морь] (11-34, 35), Э.Хэнишийн орчуулгыг засан хэвлүүлсэн В.Хайссиг германаар "die acht Pferde mit dem silbergrauen Wallach" (12-29) [нэг мөнгөн саарал агттай найман морь], С.Калужинский польшоор "osiem koni z izabelowatym walachem" (13-61) [шарга агттай найман морь], Ш.Озава японоор "usukurigeìro-no kyoseìba-nado natto-no uma-ga" [шарга агт зэрэг найман морь] (14-155, 158) гэж орчуулжээ. Эдгээр эрдэмтдээс Ш.Озава "агттан" гэдэг үгэнд тайлбар хийж, Мостэрт авгайн "МНТ"-ы "yegü, yisüngge, tuqu-tan qurban kö'üd " гэдгийн "-tan"-тай "aqta-tan"-ы "-tan"-г адилтган үзсэнийг зөвшөөрч байгаа боловч Э.Хэнишийн "aγtatai"-н

олон тооны хэлбэр гэж үзэж орчуулсныг буруутгахад бэрхтэй (14-77, 78) гэсэн ац санал дурджээ.

Дүгнэн хэлэхэд, дундад үеийн монгол хэлний хоёр зүйлийн "-tan" дагаврыг ялган салгаж, ялангуяа товчлон хураах, хүндэтгэх утгатай "-tan" дагаврын судалгаа хомс байсан хийгээд хожмын сурвалж бичгүүдэд "Чингисийн найман шарга" гэж түгээмэл тэмдэглэж ирсэн нь "МНТ"-г судлан орчуулагчдад зохих бэрхшээл, төөрөгдлийг буй болгосон бололтой.

Дундад үеийн монгол хэлний "-tan" хэлбэрт хоёр зүйлийн дагаврын судалгаа

Дундад үеийн монгол хэлэнд нэр үгээс тэмдэг нэр бүтээдэг "-tai, -tei", "-tu, -tü", "-tan, -teṇ" гэсэн хэлбэртэй нэгэн дагаврын гурван хувилбар байсан бөгөөд тэдгээр нь тухайн нэр үгээр илэрсэн юм, шинж чанарын буй бүхүйг заасан утгыг илтгэдэг. Энэ гурван хувилбарын ялгаа гэвэл, "-tai, -tei" нь ганц тооны эм хүйсийг, "-tu, -tü" ганц тооны эр хүйсийг, "-tan, -ten" нь хүйс үл ялган, олон тоог заадаг байжээ. (Дундад үеийн монгол хэлэнд нэлээд тогтвортой хадгалагдсаар байсан хүйс заах ёс гэдэг бол энэтхэг-европ язгуурын хэлнийх шиг хийсвэр хэлзүйн хүйсийг хэлсэн биш, байгалийн хүйс буюу тухайн юм, үйлийн эзэн болсон хүн, амьтны хүйстэй холбогдсон өвөрмөц зүйл болохыг энд тайлбарлах нь илүүц буй заа. Ш.Ч)

"-tai, -tei", "-tu, -tü" хоёрын хүйс ялган зааж байсныг "МНТ"-нд тохиолдох нэгэн хэллэгийн хоёр тохиолдлоос ажиглая. "МНТ"-нд Бөртэ үжиний төрх байдлыг өгүүлэхдээ, "öki inu üǰebesü ni'ür-tür-iyan geretei nidün-tür-iyen qaltai ökin-i üǰeǰü oyin-tur-iyan oro'ulba" (1-26) [түүний охиныг үзвээс нүүртэй гэрэтэй (гэрэлтэй), нүдэндээ галтай охиныг үзэж ойндоо оруулав] гэсэн байдаг бол Тэмүжиний дүр төрхийг мөн үгээр дүрслэн хэлэхдээ, "ene kö'ün cinu nidün-tür-iyen qaltu ni'ür-tür-iyan geretü kö'ün bui" (1-25) [Энэ хөвгүүн чинь нүдэндээ галт, нүүрдээ гэрт (гэрэлт) хөвгүүн буй] гэжээ. Энэ хоёр жишээний "geretei" (гэрэлтэй), "geretü" (гэрэлт), "qaltai" (галтай), "qaltu" (галт) гэсэн үгсийг хам сэдэвтэй нь харьцуулахад, хүйс заасан ялгавар тов тод ажиглагдана.

"-tan" дагаврын судалгаанд үл хамаарах нэгэн санаа эндээс төрснийг дурдвал, "нүдэндээ галтай, нүүрдээ гэрэлтэй" гэдэг тогтвортой хэллэгийг "МНТ"-нд хэрэглэхдээ, яагаад эм хүний тухайд "нүүр" гэж эхлээд, эр хүний хувьд "нүд" хэмээн эхлэн өгүүлэв? Тэр цагт, ер нь монголчууд эм хүний нүүр царайг, эр хүний хурц сэргэлэн харц хараг эрхэмд үздэг байсны гэрч гэлтэй.

Өгүүлэн буй нэгэн дагаврын гурван хувилбарыг "su" (суу) гэсэн нэг үгэнд залгаж, "МНТ"-нд хэрхэн хэрэглэснийг ажиглая. "МНТ"-ны 111-р зүйлд "...qunar mawui cilger bi qutuqtai sutai üǰin-i quriyaǰu iregü bolun qotola merkit-e huntawu bolba" (1-46) [хунар муу Чилгэр би хутагтай суутай Үжинийг хурааж ирэх болон хотол Мэргидэд унтуу болов] гэж Бөртэ үжинийг "суу" гэсэн үгээр тодотгохдоо "sutai" (суутай) гэсэн бол, мөн үгээр

Чингис хааныг тодотгохдоо "&272... sutu cinggis-qahan ecige bidan-u de'ere aqa-nar dōro de'üner bö'etele qahan aqa-yi cimayi aqta metü songquju..." (1-164) [суут Чингис хаан эцэг бидний дээр ах нар, доор дүү нэр бөгөөтөл хаан ахыг чамайг агт мэт сонгож...] хэмээн "sutu" (суут) хэлбэрийг хэрэглэжээ. "МНТ"-ны 74-р зүйлд "...sölsütei töreksen üjin eke sutan kö'üd-iyen teji'erün cigörsün sirō barijju südün cicigina uquju teji'ebi" (1-28) [селстэй (цөстэй) төрсөн Үжин эх суутан хөвгүүдээ тэжээрүүн, чигүрсэн шор барьж, сөд чичгэнэ ухаж тэжээв] гэсэн жишээнд Өэлүн эхийн хөвгүүдийг "суу" гэдэг үгээр тодотгохдоо "sutan" (суутан) хэлбэрийг хэрэглэсэн байна. Энд эшлэсэн жишээнээс ажиглахад, тодотгуулагч нь эм бол "sutai" (суутай), эр бол "sutu" (сууг), олон тоотой бол "sutan" (суутан) гэж хэрэглэх хүйс, тооны нарийн ялгамж байжээ. Гэхдээ эртний монгол хэлний хүйс, тоогоор зохицох тогтолцоо нь 13-р зуун гэхэд нэгэнт суларч ирснийг бас анхаарах ёстой.

Олон тоот тэмдэг нэр бүтээдэг "-tan, -ten" дагаврыг гарал үүслийг ихэнх судлаачид, ганц тооны эр, эм хүйсийг заадаг "-tu, -tü", "-tai, -tei" дагавар дээр дундад үеийн монгол хэлний олон тооны дагавар "-n"-ийг залгаж бүтсэн гэж үздэг. Харин Г.И.Рамстедт түнгүүс хэлнүүдийн олон тооны дагавар "-tan, -ten" болон манж хэлний "-ta, -te"-тэй холбосон (15-59) бол М.Н.Орловская нивх хэлэнд монгол хэлнийхтэй яг адил хэлбэр, утгатай "-tan" дагавар байдаг бөгөөд тэр нь хүмүүс, гэр бүлийн хам олныг заасан нивх хэлний биеэ даасан үгээс гаралтай болохыг дурдаж, монгол хэлний "-tan" дагаврыг бүтээвэр болж задрахгүй (16-58) гэж үзжээ.

Дундад үеийн монгол хэлэнд "-tai, -tei", "-tu, -tü" дагаврын олон тоот хэлбэр болж байсан "-tan, -ten" нь орчин цагийн монгол хэлэнд үг бүтээх дагавар болжээ. Гэвч амь-амьтан, жигүүр-жигүүртэн, оюун-оюутан гэх мэтээр тухайн нэрээр илэрсэн юм, шинжийг агуулсан нэгэн зүйл, хэсэг олны нэрийдэл болдог нь олон тоог зааж байсны ор мөр юм.

Ер нь дундад үеийн монгол хэлний үед ч "-tan, -ten" дагавар бүхий тэмдэг нэр нь жинхэнэ нэрийн утгаар хэрэглэгдэж эхэлсэн нь тухайн үеийн хэлний баримтаас мэдэгдэнэ. "МНТ"-ны 224-р зүйлд: "...cinggis-qahan jarliq bolurun urida nayan kebte'ülsütü dalan turqaq kesiktentü büle'e... " (1-128) [Чингис хаан зарлиг болруун: Урьд наян хэвтүүлст, далан турхаг хишигтэнт бүлгээ] гэсэн хэсэгт гарч буй "kesik" (зэлж, хувь) хэмээх үгэнд олон тоот тэмдэг нэр бүтээдэг "-ten" дагаврыг залган, жинхэнэ нэр бүтээж, бас дахин "-tü"-г залгаж хэлбэржүүлсэн содон жишээ тохиолдож байна.

Дахин нэг жишээ өгүүлэхэд, Чингис хааныг Сартуул иргэнд дайлахаар мордох үед Есүй хатны дуртган сануулсан үгэнд "...töreksen ele amitan-tur möngke ügei aju'u" (1-149) [Төрсөн л амьтанд мөнх үгүй ажгуу] гэж гарч буй. Амь гэдэг үгэнд "-tan" залгаж, жинхэнэ нэр бүтээсэн энэ үг "МНТ"-ны зөвхөн энэ хэсэгт л тохиолдоно.

Өдгөө хүртэл олдож мэдэгдсэн, дөрвөлжин үсгээр буй монгол хэлний 50 гаруй дурсгалын хэлийг шүүн үзэхэд, "амьтан" ᠰᠢᠷᠤᠭᠤᠨ гэдэг үг Цавчаал боомтын зүүн, баруун хананы бичээс (1345), Тогоонтөмөр

хааны 1368 оны зарлигт нийтдээ найман удаа тохиолдох бөгөөд тэдгээр нь бүгд жинхэнэ нэрийн утгатай байхаас гадна сонирхол татах нэгэн зүйл бол "...talayi buyanu'ud-i 'amit'an-a ǰalqamǰi bolqabayi..." (17-171) [...далай буянуудыг амьтнаа залгамж болговой], "...talayi 'amit'an-i ǰirqalaŋ-dur ǰoqiyaqu bolt'uqayi..." (17-172) [...далай амьтныг жаргаланд зохиох болтугай] гэх мэтээр Бурханы сургаал номын үгст л холбогдон гарах юм. "МНТ"-д ганцхан удаа тохиолдох "Төрсөн л амьтанд мөнх үгүй ажгуу" гэсэн жишээ маань ч орчлонгийн мөнх бусыг айлдсан Бурхан сургаалын үг мэт санагдаж байна. Дээр өгүүлсэн Есүй хатны сануулгын үг нь дөрөв дөрвөн мөрөөр хайрцагласан гурван бадаг шүлэг байгаа бөгөөд "Төрсөн л амьтанд мөнх үгүй ажгуу" гэсэн өгүүлбэр ер авцалдахгүй завсраар нь нэмсэн мэт ажиглагдана. Яргуулж ярьсан энэ үгс маань "-tan" дагаврын судалгаанаас хэт холдсон тул цухас тэмдэглэн орхиё.

Олон тоот тэмдэг нэр бүтээх "-tan, -ten" дагаврын үг бүтээх бас нэг утга нь товчлон хураах болон хүндэтгэх санааг илтгэдэг байсныг зарим судлаач гярхай ажигласан байдаг. Г.И.Рамстедт "-tan, -ten" дагаврыг зарим тохиолд хүндэтгэлийн утгаар хэрэглэдэг гээд, "lama-tan-dur" (ламтанд) гэсэн жишээ татжээ (15-59). Профессор Баошаан 1340 оны Аруг вангийн хөшөөний бичээст тохиолдох "...bayiqu ahöwe tügel-ten (tan Ш.Ч) köbegüd dayiǰiγsan-u qoyin-a..." (18-71) гэсэн хэсгийн "tügel-ten (tan Ш.Ч)"-ий "-tan"-ыг тайлбарлахдаа: " [illegible] " (-tan, -ten) бол нэгэн зүйлийн дагавар болно. Одоо үеийн монгол хэлэнд, нэр үгээс дам нэр үг үүсгэхэд хэрэглэж, тухайн юм бүхүй хүнийг заасан, эсэхүл нэгэн төрлийн олон юмыг заасан үг бүтээдэг... Монгол эртний дурсгалын зүйлүүдээс ажиглавал, ийм утгаар түгээмэл хэрэглэгдэж байснаар барахгүй, бас зэрэгцсэн гишүүнийг хураасан утгаар мөн өргөнөөр хэрэглэгдэж байсан байна. "МНТ"-нд "senggüm-bilge ambaqai-tan" гэж хэрэглэсэн нь тус хөшөөний " [illegible] " гэж хэрэглэсэнтэй адил байна" (18-78) гэжээ.

Харин сүүл үеийн зарим судалгаанд, тухайлбал Өвөрмонголын судлаач М.Баатар, Юй-Чиан нар "МНТ"-ны баримтыг гол болгон, энэхүү "-tan" хэлбэрийг, дундад үеийн монгол хэлний олон тоот тэмдэг нэр бүтээдэг "-tan, -ten"-ээс өөр зүйл болохыг тэмдэглэж, "хураах утгыг илтгэдэг –tan" (19-30), "хураах дагавар үг -tan" (20-60) гэж нэрлэсэн байна. Харин тус дагаврын хүндэтгэх утгын тухайд тодорхой юм хэлээгүй нь түүний гарлыг өөрөөр үзсэнтэй холбоотой бололтой.

"МНТ"-нд элбэг тохиолдох олон тоот тэмдэг нэр бүтээх "-tan, -ten" дагавар бүхий "oboqtan" (овогтон), "öšten" (өштөн), "numutan" (нумтан), "nereten" (нэртэн), "honcitan" (ончтон), "öčilten" (өчилтөн), "ciraitan" (царайтан), "eyeten" (эетэн), "a'urtan" (ууртан), "ǰasaqtan" (засагтан),

---

* Аруг вангийн хөшөөний бичээсийг судлан шинжилсэн профессор Ф.В.Кливез (21-43), эрдэмтэн Х.Лувсанбалдан (22-125), Б.Булаг (23-288) нар Баошааны нэгэн адил өмнөх үгтэй нь эр, эмээр зохицуулан дуудаж, "-ten" гэж галиглажээ. Энэ дурсгалын "tügel" гэдэг хүний нэрийн ард саланги бичсэн " [illegible] " гэсэн хэлбэрийг "-tan" гэж уншиж галиглах ёстой болох нь эл өгүүллийн судалгаагаар нутлагдаж байна.

"itegelten" (итгэлтэн), "gereten" (гэрэлтэн) гэх мэт үгсээс, товчлон хураах, хүндэтгэх утгат "-tan" дагавар бүхий үгс ямар ялгаатайг тод харуулахын тулд "МНТ"-ны хэдэн жишээг хам үгстэй нь доор сийрүүлье.

1. МНТ &99 "...temüǰin-tan kö'üt öterlen-gü bosu'at morid-iyan barǰu..." (1-38)
   Да.О* "...Тэмүжин нар даруй босоод морьдоо барьж..." (24-55)
   Цэ.О** "...Тэмүжин нарын хөвүүд түргэлэн босоод морьдоо барьж..." (25-53)
2. МНТ &120 "...basa mönggetü kiyan-u kö'ün öngger-tan cangsi'ut baya'ud-iyar-ān ayisun-gü aǰu'u" (1-49)
   Да.О "...бас Мэнгиту хианы хөвүүн Үнгүр нар, чаншиут баяут харьяат нараа дагуулж ирэв..." (24-72)
   Цэ.О "Бас Мүнгэту хианы хөвүүн Үнгүр нар Чаншиуд Баягуудаараа айсуй ажгуу" (25-66)
3. МНТ &156 "...tende cinggis-qahan dotora-'an setkiǰü bo'orcu muqali-tan noyad-i uriǰu ire'üǰü ügülerün..." (1-73)
   Да.О "...Үүнд Чингис хаан дотроо сэжиг авч, Боорчу Мухулай хоёр ноёныг урьж ирүүлээд өгүүлрүүн..." (24-115)
   Цэ.О "...Тэнд Чингис хаан дотроо бодож, Боорчу Мухалитан ноёдыг урьж ирүүлж өгүүлрүүн..." (25-89)
4. МНТ &203 "...sigi-qutuqu ö'er-iyen teyin soyurqa'ulun baraǰu qarcu bo'orcu muqali-tan noyad-i uriǰu oro'uǰu'u..." (1-116)
   Да.О "...Шигихутаг өөрөө хаанаас соёрхлыг олж төгсөөд гарч, Боорчи, Мухулай тэргүүтэн ноёдыг урьж ирүүлэв." (24-180)
   Цэ.О "...Шигихутаг өөрийгөө тийн соёрхуулан, гарч Боорчу, Мухулитан ноёдыг урьж оруулжээ." (25-134)
5. МНТ &230 "...yisün-te'e bügidei-tan qorcin-i yekes qorcin kē'etkün ke'en ǰarliq bolba..." (1-133)
   Да.О "...Есөнтэй, Бүхэдэйн харьяат
   Ерөөлт хуучин хорчныг
   Ерөнхий хорчин гэгтүн гэж зарлиг болов" (24-204)
   Цэ.О "...Есүнтэгэ, Бүгидэйтэн хорчныг ихэс хорчин хэмээгтүн хэмээн зарлиг болов" (25-153)

Өмнө эшлэсэн таван хэсгийг академич Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нар орчин цагийн монгол хэлэнд хэрхэн хөрвүүлсэнийг ажиглахад, дундад үеийн монгол хэлний "-tan" залгаврыг, заримдаа хэвээр нь, заримдаа "нар, хоёр, тэргүүтэн" зэрэг хураах үгээр буулгажээ.

Энэхүү товчлон хураах, хүндэтгэх утгат "-tan" залгаврын жишээг "МНТ"-оос гадна монгол үгийг хятадаар галигласан 14-р зууны үеийн хэлний дурсгалууд, тухайлбал "Хуа-й-й-юй" бичгийн зүйлүүдээс үзэж

---

* Академич Ц.Дамдинсүрэнгийн "МНТ"-ы орчуулгыг Да.О гэж тэмдэглэв.

** Академич Д.Цэрэнсодномын "МНТ"-ы орчуулгыг Цэ.О гэж тэмдэглэв.

болно. Жишээлбэл, Мин улсын хаанд явуулсан Нэхлэй[***] ноёны бичиг (1388)-т "arıγbuq-a-yin uruγ-un kümün yesüder-tan oyirad-luγ-a bolun dayiǰiǰu qaγan-i manu güǰilen önggeregülüged yeke tamaγ-a-yi abču irgen oγun-i ečüdken bürilgekü-yin tula ba nekeleyi-tan tüsimed ba cerig ulus-iyar bürin eyedündüǰü (eyedüldüǰü)..." (26-302) [Аригбухагийн ургийн хүн Есүдэртэн ойрд лугаа болон дайжиж, хааныг маань гүжирлэн өнгөрүүлээд их тамгыг авч иргэн оргоныг эцэтгэн бүрэлгэхийн тул ба (бид) Нэхлэйтэн түшмэд ба (бид) цэрэг улсаар бүрэн эдэлдэж...] гэж буй. Эшлэсэн хэсэгт гарч байгаа Есүдэр, Нэхлэй гэсэн хүмүүсийн нэрд залгасан "-tan" залгаврыг хятадаар орчуулахдаа, "МНТ"-ны адил " 等 děng" (зэрэг, -нар, мэт) гэсэн үгийг хэрэглэсэн байх ба утга нь ч товчлон хураасан санааг агуулжээ.

Товчлон хураах утгат "-tan" залгаврын талаарх сурвалж бичгийн баримт жишээг үүгээр хязгаарлаж, дундад үеийн монгол хэлэнд байсан хоёр зүйлийн "-tan" дагаврын зааг ялгааг гаргахыг хичээе.

1. Илтгэх утгаараа ялгаатай байжээ. Тэмдэг нэрийн олон тоот хэлбэр бүтээж байгаад аажимдаа жинхэнэ нэр үүсгэх болсон "-tan" дагавар нь тухайн үгээр илэрсэн юм, шинж тэмдэг буй бүхүйг илтгэдэг. Нөгөө "-tan" хэлбэр нь өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүнийг товчлон хураах, хүндэтгэх утгатай бөгөөд орчин цагийн монгол хэлэнд нэлээд тохиолдолд "-нар, тэргүүтэн, зэрэг" гэх мэт хураах үгсээр сольж найруулж болно. "МНТ"-ны хэлийг нягтлан үзэхэд, энэхүү "-tan" дагаврыг "teri'üten" (тэргүүтэн) [түрүү бүхүй] гэдэг үг түрж эхэлсэн байдал ажиглагдана.
2. Хэлзүйн хэлбэрийн хувьд, олон тоот тэмдэг нэр бүтээдэг "-tan" нь эм үгэнд залгах "-ten" гэсэн хувилбартай байсан бол нөгөө "-tan" нь нэг л хувилбараар тохиолдоно. Уйгуржин монгол бичгийн дурсгалд "а", "э" нь ялгарахгүй боловч "МНТ" зэрэг монгол үгийг харь хэлний үсгээр галигласан дурсгалаас тодорхой харагдана. "МНТ"-нд "temüǰin-tan" (1-38), "öngger-tan" (1-49), "bükidei-tan" (1-135) зэрэг тодорхой ялгасан жишээ тохиолдох бөгөөд заримдаа галиглагч хутган эндүүрсэн тал ч хааяа үзэгдэх ажээ.
3. Гарлын тухайд мөн ялгаатай гэж үзэж байна. Олон тоот тэмдэг нэр бүтээдэг байсан "-tan, -ten" нь гарлаараа "-tu, -tü+n", "-tai, -tei+n" гэсэн бүтээвэр болж салах тухай өмнө өгүүлсэн. Харин товчлон хураах, хүндэтгэх утгатай "-tan" нь өвөг болон эртний монгол хэлний хоёрдугаар биеийн төлөөний нэрийн олон тооны хэлбэр "tan" (27-5,7) -аас улирч хувьсч иржээ.

[***] Нэхлэй уул нь Тогоонтөмөр хааны үед цэрэг дайны хүрээлэнгийн ноён байжээ. 1387-1388 оны үед, Төгстөмөр хаан, Мингийн цэрэгтэй Буйр нуурын хавьд байлдахад Нэхлэй байжээ. Монгол цэрэг ялагдаж, Төгстөмөр хаан, түм гаруй цэрэг морьтой баруунш дутаахад Нэхлэй бас байжээ. Төгстөмөр хаан Есүдэрт хорлогдсоны дараа Нэхлэй Мингийн талд бууж өгчээ. Мингийн талд шударга байхаа илтгэсэн энэ бичгийг 1388 оны өвөл бичсэн ажээ" (26-304, 305, 310).

Ийм саналыг эрдэмтэн Сэцэнцогт дурдаж, зүүн ёгур хэлэнд "gaga" (ах)- "gagatan" (ах зэрэг хүмүүс), дунсян хэлэнд "očin jian" (охин дүү)-"očin jiantaŋ"(охин дүү зэрэг хүмүүс), монгор хэлэнд "budaŋ (бид)" - "budaŋtaŋ (бид нар), "deu" (дүү), -"deutaŋ"(дүү нар) гэж байдаг төрөл хэлний баримтуудыг тэмдэглэжээ (28-2768).

Энэ завсарт тэмдэглэн хэлэхэд, Австралийн нэрт монголч эрдэмтэн И.Рахевилц "товчлон хураах, хүндэтгэх утгатай "-tan" хэмээж, бидний энд өгүүлж буй дагаврыг "enclitic" (үгийн хойно дагалдагч өргөлттэй үг) гэж нэрлээд, "-tai, -tei"-гийн олон тоот хэлбэр "-tan, -ten"-ээс ялгахын тул зураас татан галигласнаа дурдсан байна (1-10).

Орчин цагийн монгол хэлэнд "-tan" гэсэн хоёрдугаар биеийн төлөөний нэрийн үндэс нь зөвхөн хүндэтгэх утгаар "таны, танд, танаас..." гэх мэтчилэн хэрэглэгдэж байдаг нь бидний бодлыг улам лавшруулж байна.

4. Зөв бичих дүрмийн талаар, олон тоот тэмдэг нэр бүтээдэг "-tan, -ten" дагаврыг ихэнхдээ хамт бичиж, нөгөө "-tan" дагаврыг дагуулах үгнээсээ саланги бичдэг байсныг уйгуржин монгол бичгийн эртний дурсгалуудаас мэдэж болно.

Мөн "МНТ"-ны уйгуржин монгол эхэд ийм байсан гэдгийг Лувсанданзаны "Алтан товч"-оор нуталж болох юм. Лу "Алтан товч"-д ямагт " " гэж саланги бичсэн байдаг.

5. Ямар үгэнд залгаж, үг бүтээдэгээр нь ялгаж болно. Олон тоот тэмдэг нэр бүтээдэг "-tan, -ten" дагаврыг ерийн нэр үгийн хойно залгасан байхад, нөгөө товчлон хураах, хүндэтгэх утгат "-tan" дагаврыг зөвхөн оноосон нэр тэр тусмаа хүний нэрийн ард залгаж байжээ. "МНТ"-нд "temüjin-tan", "bo'orcu muqali-tan", "dödei doqolqu-tan", "dergek emel alqui-tan", "a'ucu ba'atur-tan" гэх зэргээр хүний нэрийн хойно л тохиолдох бөгөөд "isebür"* гэдэг хотын нэрд залгасан нэг жишээ байх боловч цөөн мөрийн өмнө "isebür teri'üten" (1-155) гэж бичжээ. Харин агт гэсэн үгэнд залгасан 12 жишээ бол онцгой үзэгдэл юм. Үүний учрыг хойно тайлбарлах болно.
6. Энэ хоёр зүйл "-tan" дагаврын орчин цагийн монгол хэлэнд үг бүтээх утга нь улирч өөрчлөгдсөний сацуу хэрэглэгдэх хүрээ бүтээлч шинж нь ч адилгүй болжээ. "-tan, -ten" дагавар нь тун идэвхтэй жинхэнэ нэр бүтээхэд хэрэглэгдэж байхад, нөгөө товчлон хураах, хүндэтгэх утгат "-tan" дагавар нь зөвхөн хүндэтгэсэн утгаар "хаан-хаантан, эзэн-эзэнтэн, гэгээн-гэгээнтэн, ноён-ноёнтон, лам-ламтан, багш-багштан" зэрэг цөөн тогтсон үгийн хэмжээнд хэрэглэгдэж, дундад үеийн монгол хэлэнд илтгэж байсан товчлон хураах гол утга нь үгүй болжээ.
7. "МНТ"-ны хятад галигийн хажууд хадсан энэ хоёр зүйлийн "-tan" дагаврын хятад орчуулга нь тогтвортой ялгасан өөр өөр үг байдаг.

---

* "Nīshāpūr" (8-315) гэдэг хотын нэрийг "isebür" гэж хятадаар галигласан нь галиглагчийн алдаа юм. " " гэж уйгуржин монгол эхэд нь үгийн эхний "ni-" гэсэн үед цэг тавиагүй бичсэнийг "i" гэж бодоод, үг үгийг бүхэлд эм эгшигт үгээр уншжээ. Мэдээж хэрэг 14-р зууны үе хятадад амьдарч суусан бичгийн хүнд дундад Азийн хот балгадын нэр ер сонсоогүй зүйл байсан биз ээ.

Олон тоот тэмдэг нэр бүтээх "-tan, -ten" дагаврыг " 有 yǒu [буй, байх, -тай[3]] (10-1960)", " 每 měi" [тутам, үргэлж, бүр] (10-1042) гэсэн үгээр орчуулсан бол товчлон хураах, хүндэтгэх утгат "-tan" дагаврыг " 等 děng" [зэрэг, -нар, мэт] (10-302) гэсэн үгээр орчуулжээ. Уйгуржин монгол эхийг хятадаар галиглан орчуулах үе буюу 14-р зууны сүүл үеийн бичгийн хүнд энэ хоёр зүйлийн "-tan" дагаварт үгсийн утгын ялгаа тодорхой байсан биз ээ.

Энд хүртэл дундад үеийн монгол хэлэнд хоёр зүйлийн "-tan" дагавар байсан болохыг тодруулан өгүүлэв.

"Шарга агттан"-ы "-tan" дагаврыг алинаар үзэх вэ?

"МНТ"-нд 12 удаа тохиолдох "aqta-tan" (агттан) гэдэг үгэнд өмнө өгүүлсэн хоёр зүйлийн "-tan" дагаврын алиныг залгасан болохыг тодотгон өгүүлье.

1. Орчин цагийн монгол хэлний нэр үгээс тэмдэг нэр бүтээх "-тай, (-той, -тэй)" болон "-т, (-tu,-tü)" дагавартай утга гарал нэг дундад үеийн монгол хэлний олон тоот тэмдэг нэр бүтээх "-tan,-ten" дагаврыг агт гэдэг үгэнд залгажээ гэж үзвэл "шарга агттай найман морь" буюу "шарга агт бүхий найман морь" гэсэн утгатай болно. Харин хэд хэдэн шарга агт бүхий найман морь гэж өгүүлэх байсан бол дундад үеийн монгол хэлний хүйс, тоо зохицох тогтолцоо ёсоор "sirγad aγtastan naiman morid" [шаргад агтастан найман морьд] гэж байх ёстой.

Агт гэдэг үг нь олон тоонд байвал зүс заасан тодотгол нь мөн олон тоогоор зохицож байсныг "МНТ"-ны 239-р зүйлийн жишээ гэрчилж байна. Тэнд "...cinggis-qahan-tur caqa'a-nu'ut singqot-iyar caqa'a-nu'ut aqtas-iyar qara-nu'ut buluqat-iyar a'ulja'ulba" (1-137) [Чингис хаанд цагаанууд шонхдоор, цагаанууд агтасаар, харнууд булгадаар уулзуулав] гэж гарах ба энэ жишээ "цагаанууд агтас" гэдгийн адилаар "шаргад агтас" гэж байх учиртай тул "шарга агттан" гэдгийн "шарга"-д олон тооны дагавар залгаагүй байгаа нь нэг шарга агт байсны гэрч гэж үзэж болно.
2. Дундад үеийн монгол хэлний товчлон хураах, хүндэтгэх утгатай "-tan" дагаврыг залгасан гэж үзвэл "шарга агт тэргүүтэй найман морь", "шарга агт зэрэг найман морь" гэсэн утгатай болно. Ингэж үзэх нь хятад галигийн хажуугийн хадмал орчуулгад " 等 děng" (зэрэг, -нар, мэт) гэсэнтэй яв цав нийцэх болно. Гэвч ингэж үзвэл, энэхүү "-tan" дагаврыг хүний оноосон нэрд л голлон хэрэглэдэгтэй зөрчилдсөн нэгэн онцлог үзэгдэл болох юм. Энэ онцлог шинж байж болохыг шарга* зүсийг эрхэмлэх монголчуудын сэтгэлгээ, зан үйлээс эрэх хэрэгтэй болно. Хольцоогүй дан шарга зүстэй адуу тун ховор бөгөөд тийм зүстэй морь, азаргыг ихэд онцлон үздэг. Ардын дуунд

---

* Баруун монголын аялгуунд шархал гэж хэлдэг.

"ардаг баахан шарга", "нарийн шарга", "газрын холоос гүйдэлтэй алтан шаргал морь", "тогослаа шарга", "цагаанлай шархал морь", "сэтэрт баахан шарга", "жаахан шарга", "цэвцгэр хурдан шарга", "өндөр сайхан шарга", "шалзат баахан шарга" гэх мэт өдий төдий шарга зүст морийг магтан дуулсан байдгийг санах хэрэгтэй.

Доктор С.Дулам "Өнгөний бэлгэдэл зүй" хэмээх номдоо "Шарга(л) зүсмийн бэлгэдэл" гэж тусгайлан гарчиглаж, олон сонин баримт дурдсаны дотор бөөгийн онгон шүтээний зарим нь шарга морь хөлөглөсөн байдгийг өгүүлж, "халх, хотгойд нарын шүтдэг шарын бөөгийн дээд шүтээн Даян дээрх Далх вандад нь цагаан шаргал халзан морь хүлэглэдэг" (29-91) гэжээ. Академич Ч.Далай "Ер нь Тэмүжин найман шарга морио эрж явсан газар нь одоогийн Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутаг Даян дээрхийн хавь газар байсан бололтой байдаг. Энэ тухай ардын домог ч бий" (30-42) гэжээ. Академич Ч.Далай "Ер нь Тэмүжин найман шарга морио эрж явсан газар нь одоогийн Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын нутаг Даян дээрхийн хавь газар байсан бололтой байдаг. Энэ тухай ардын домог ч бий" (30-42) гэжээ. Чингис хаан Даян дээрхийг тахих болсон тухай домгууд эш татсаныг, С.Дуламын бичсэнтэй шүтэлдүүлэн үзэж ч болмоор санагдана.

"Адууг сэтэрлэх явдал эрт цагаас эхэлсэн ба энэ нь бөөгийн мөргөлийн гол зүйлийн нэг болж ирсэн" (31-8) ажээ. XIII зууны үед, Ромын шашны элчээр Монголд ирж, Гүег хаанд бараалхаж явсан Плано Карпини "Онгон шүтээндээ агт морь сэтэрлэн өргөх бөгөөд түүнийг үхэн үхтэл нь хэн ч унаж мордох ёсон огт үгүй" (32-16) гэж тэмдэглэсэн нь нүдээр үзсэн хүний лавтай үг билээ. Энэ бүгдийг эргэцүүлэн бодоход, Тэмүжиний шарга агт нь эцэг тэнгэрт өргөж, онголон дархалсан хүлэг агт байсан тул "шарга агттан" хэмээн хүндлэн дээдэлж нэрлэсэн бололтой. Ингэж үзвэл, хүний оноосон нэрд л бараг төлөв залгадаг, товчлон хураах болон хүндэтгэх утгатай "-tan" дагаврыг залгасны учир тайлагдах болов уу.

Академич Ш.Нацагдорж "Тэмүжиний бүх адуу нь ердөө тэрүүхэн хэдэн шарга морь байсан юм уу, эсвэл энэ нь сэтэрлэсэн онгон морьд байсан юмуу. Монголд жаргалын найман хүлэг морины тухай яриа байдаг, ямар боловч найман шарга морийг унаж эдэлдэггүй, ардаг тарган байлгадаг байсан бололтой" (33-34) гэж бичжээ. Академич Ш.Нацагдорж гуайн эргэлзэн өгүүлснийг "МНТ"-ны баримтаар тайлбарлаж болмоор байна.

Тэр үед Тэмүжинийд ердөө л 9 морь байсан бөгөөд "МНТ"-ны 77-р зүйлд "...bekter hulqun de'ere sirqa aqta-tan yisün mori[t] qaraju sa'u büküi-tür..." (1-29) [Бэгтэр улхан (довцог) дээр шарга агттан есөн морио харж суун бүхүйд] гэсэн нь оготор дарги хонгор оролцоод есөн морь болж байгаа хэрэг. Энэ жишээнээс нэгэн зүйлийн маргаантай буюу ташаа ойлголт болох "найман шарга агт" гэдгийг залруулж болно. "Шарга агттан есөн морь" гэж өгүүлсэн нь нэг онгон шарга агттай есөн морийг хэлсэн бөгөөд оготор дарги хонгорыг шарга агт гэж хэлэхгүй нь лавтай юм. Дундад үеийн монгол хэлний дурсгал болох "Монгол хуа-и-и-ю" толь бичгийн зүйлүүдэд хонгор морь, шарга морь гэж ялган жагсаасан байдгийг энд нэмэр болгон дурдая.

Тэмүжин "шарга агттан найман морь"-оо олж ирээд удаагүй байтал Мэргидүүд, Есүхэй баатар Өэлүн үжинг булаан авсан эртний

өшийг өвөрлөн довтлоход, Хуагчин эмгэний сонор соргогийн ачаар яаран сандран босч, дутаах үес Тэмүжин, Өэлүн эх, Хасар, Хачиун, Тэмүгэ-отчигин, Бэлгүтэй, Боорчи, Зэлмэ нар найман морь унаж, нэг морь хөтөлж явсан байдаг. Энд нэгэн гайхах зүйл бол хөтөлж явах морь байсаар байтал яагаад Бөртэ үжинд унуулсангүй билээ?! Магадгүй, тэнгэрт өргөж, онголж сэтэрлэсэн морийг унаж эдэлдэггүй, тэр тусмаа эмэгтэй хүнд бүр унуулдаггүй байсан ёс заншлаас болсон ч байж мэдэх юм.

"МНТ"-нд гарах агт, морь, адуу хэмээх үгсийн ялгамж хийгээд "шарга агттан найман морьд"

"МНТ"-нд тохиолдох агт, морь, адуу гэсэн үгсийг хам сэдвийн дотор нь бүртгэн судалж, гол болон дэд утга нь юуг зааж байв гэдгийг тодруулан үзэхэд, агт гэж агталсан, нас бие гүйцсэн, эр цэрэг, өртөө улааны унаа болж чадах, шилж сонгосон сайн морийг нэрлэж байжээ.

"МНТ"-ны хэлнээс ажиглахад, "эрийн эгэмд, агтын харгамд (хондлойд) хүргэх", "эрийн ар, агтын харгам эс үзүүлэх" (дайн байлдаанд үл ухрах гэсэн утгаар), "агт мэт сонгох", "харгам сайн агт", "хүлэг агт" гэх мэт тогтсон хэвшмэл үг хэллэг ч байдаг.

"МНТ"-нд "эр агт" гэсэн хэллэг 5 удаа тохиолдох бөгөөд цөм эр цэрэг гэсэн утгатай ажээ. Түүнээс хоёрыг жишээ татъя:

"& 260... sarta'ul irgen-i edüi doroyita'uluqsan-tur ba olon ere aqta cinu bayascu maqaiju amui" (1-156) [(Сартуул иргэнийг өдий доройтуулсанд ба (бид) олон (эр агт) цэрэг эрс чинь баясч махайж амуй);

"&279...basa aqa de'ü olon ere aqta kesikten ci'ulu'asu undān tere tutum irgen-ece ker qubciqdaqui" (1-171) (Бас ах дүү олон эр агт (цэрэг эр) хишигтэн чуулбаас ундаан тэр тутам иргэнээс хэр (хэрхэн) гувчигдах (татварлах!)]. Энэ хоёр жишээнд тохиолдох "эр агт" гэсэн хэллэг нь хэлц үг болсон байх бөгөөд агт гэдэг үгийн бие даасан утга үгүй болжээ. Тэр цагт цэрэг гэхэд, шандас сайт хүлэг морь, шаламгай дайчин эр хоёр л санаанд буудаг байсан биз ээ. Орчин цагийн монгол хэлэнд цэргийн морь гэдэггүй, харин цэргийн агт, цэргийн агт маллах, агтны даамал гэх зэргээр ярьж бичдэг нь эртний уламжлал ажээ. Дундад үеийн монгол хэлэнд агт гэсэн үгээ улам тодотгон өгүүлэхдээ "хүлэг" (Уг гарал нь алтай хэлний алдар цуу бүхий гэсэн үг)* гэдэг үгийг тодотгол болгон хэрэглэдэг байжээ. "МНТ"-ны 3-р зүйлд гарах "...toroqoljin-bayan boroqcin-qo'a gergeitü boroldai-suyalbi jala'utu dayir boro qoyar külü'üt aqtastu büle'e" (1-13) [Торголжин Баян Борогчин гуа гэргийт, Боролдой Суялби залуут, дайр бор хоёр хүлгүүд агтаст бүлгээ] гэсэн жишээний олон тоогоор

---

* Өгүүллийг бичигч бээр Олон улсын монголч эрдэмтдийн 7-р их хуралд "МНТ"-нд гарах "külüg" хэмээх үгийн утга, гарал хувьсал" гэсэн илтгэл тавьсан бөгөөд түүнд "хүлэг" хэмээх үгийн тухай тодорхой бичсэн бий.

зохицсон "külü'üt aqtastu" [хүлгүүд агтаст] гэсэн холбоо үг нь "алдар цуутай хоёр агт бүхий" хэмээсэн утгатай билээ.

Дундад үеийн монгол хэлнээ, агт хэмээх жинхэнэ нэрийг тодотгон орж байсан "хүлүг" гэдэг тэмдгийн нэр нь орчин цагийн монгол хэлэнд нэршиж сайн морийг заах болж, харин агт гэж нас бие жагссан, сайн морийг нэрлэж байсан жинхэнэ нэр нь морь гэсэн үгийг тодотгон хэрэглэгдэх болж, "агт морь, амбан шар" гэх зэргээр хэлэлцэх болжээ. Ер нь орчин цагийн монгол хэлэнд "Ам алдвал барьж болдоггүй, Агт алдвал барьж болдог" гэх зэрэг зүйр цэцэн үг, хэвшмэл хэллэгт л сонстохоос бус ерөнхий хэрэглэгдэх хүрээ нь их багасчээ.

Дундад үеийн монгол хэлэнд морь гэж унаж ачиж болох адууг л ерөнхийд нь нэрлэдэг байсан бөгөөд одоо ч гэсэн, тухайн хүн азарга гүү, үрээ даага алиныг унаснаар нь үл ялган "Морьтой хүн явж байна" гэж л ярьдаг. Тэр хүн тэмээ унасан биш, морь унасан гэдэг ерөнхий заагийг л онцолжээ. "Чингисийн есөн өрлөгтэй, өнчин хүүгийн цэцэлсэн шастир"-ын эхэн хэсэгт:

"Эрдэнэ морины шим сүүний дээжийг
Эрхэт тэнгэр дэлхийд өргөн тахиад..." гэж гардаг.

Энд өгүүлсэн "эрдэнэ морины шим сүүний дээж" гэж гүүний сүү, эсэг цэгээг нэрлэсэн нь лавтай.

"МНТ"-ны 174-р зүйлд Ван хан, хүү Сэнгүмээ шархадсанд ихэд уурсаж, "хөвгүүний амь өрсөн довтолъё" гэхэд Түмэн Түбэгэний Ачиг Ширүн баатар, одоо хүүгээ асаръя, Монголыг эзлэх амархан гэж Ван ханыг тайтгаруулан хэлсэн үгэнд, "...mongqol-un olonkin jamuqa-lu'a altan qucar-lu'a bidan-tur bui temüjin-lü'e dayijiju qaruqsan mongqol qa'a otqun tede morin unu'atan modun nemüreten bolba tede ani ese ire'esü otcu morin-u junda'ul metü qormailaju a[b]cirat-je bida tede'er-i" (1-85) [Монголын олонхин Жамуха лугаа Алтан Хучар лугаа бидэнд буй. Тэмүжин лүгээ дайжиж гарсан монгол хаа одох тэд! Морин унаатан модон нөмөртөн болов тэд! Тэднийг эс ирвээс одож, морины жүндуул (хомоол) мэт хормойлж авчирна зээ бид, тэдгээрийг] гэж буй. Энд "морин унаатан" гэдгийг доромжхон өнгөөр өгүүлсэн бол "морины жүндүүл" нь "адууны хомоол" гэсэн ерөнхий утгаар хэрэглэгджээ. Энэ мэт жишээ баримт нь морь гэдэг үг дундад зууны үед одоогийн утгаасаа нэлээд ерөнхий бас найруулгын өнгөөрөө агт гэдэгт үл хүрэх үг байсныг батлах ажээ. "Хорин нэгтийн тайлбар толь" (1717)-д морь гэдгийг "унах малын нэр" (34-501) гэж тайлбарласан байдгийг бас дурдая.

Ташрамд тэмдэглэхэд, монгол хэлний "morin" [морин] гэдэг үг европын хэлнүүдэд орсон байдаг бөгөөд В.Далийн "Их Оросын амьд хэлний тайлбар толь"-д "меринъ" (мерин) (35-321) гээд, монгол гаралтай болохыг тэмдэглэжээ. Мөн герман хэлэнд "mähre" гэвэл адсага гэдэг шиг муу морийг нэрлэдэг ажээ.

"МНТ"-ны хам сэдвийн ижил орчинд тохиолдох байр байдлаас нь агт, морь гэдэг хоёр үгийн найруулгын өнгө, үнэлэмжийг мэдэж болох юм. Жишээлбэл: "МНТ"-ны 193-р зүйлд "mawuqan eme'eltü singqulaqan morin" (1-101) [муухан эмээлт шунхалхан морь] гэж байдгийг, 184-р зүйлд

тохиолдох "itürgen-ü altan eme'eltü qara aqta" (1-94) [Итүргэний алтан эмээлт хар агт] гэсэнтэй харьцуулж болно. Алтан эмээлийг моринд бус агтанд тохох ажээ.

Баарины Үсүн өвгөнд бэхи цол өргөөд "caqa'an de'el emüscü caqān aqta unu'ulju sa'uri de'ere sa'ūlju takīju..." (1-125) [цагаан дээл өмсч, цагаан агт унуулж, суурь дээр суулгаж, тахиж...] байтугай гэж Чингис хаан зарлиг болсон тухай "МНТ"-ны 216-р зүйлд бий. Бэхи цол өргөн, тахиж хүндэлж байх Үсүн өвгөнд цагаан морь бус цагаан агт унуулах ёстой ажээ. "МНТ"-ны 177-р зүйлд Чингис хаан, Ван ханыг ядаж зүдэж явахад нь хэдэнтээ тусалснаа өгүүлэн, дуу бариулан илгээсэн үгэнд "...basa gür-qan-naca dajījju qarcu ui'ud-un tang'ud-un qajar-iyar yadaju ayisurun tabun ima'at sirgölejü sa'aju idejü teme'en-ü cisun qanaju idejü qaqca soqor qali'un moritu ireba-je ci" (1-88) [...бас Гүр хаанаас дайжиж гарч, уйгур, тангудын газрааР ядаж айсруун (ирэхдээ), таван ямаа шөргөлж сааж идэж, тэмээний цус ханаж идэж, ганц сохор халиун морьт ирэв зээ, чи] гэжээ. Таван ямаа шөргөлөн сааж, тэмээний цус ханаж идэж, явсан тэр үеийн Ван ханд хэрхэн агт байх аж.

Адуу гэдэг үг "МНТ"-нд орчин цагийн монгол хэл шиг таван хошуу малын нэгнийг нэрлэхийн хамт ихэнх зонхидоо мал сүрэг, мал хөрөнгө гэсэн утгыг илтгэж байжээ. "МНТ"-ны хэдэн хэсгийг эшлэе:

"&23...eke-yü'en alan-qo'a-yi ügei boluqsan-nu qoyina aqa-nar de'ü-ner tabu'ula adūsun ide'e-ben qubiyaldurun..." (1-16) [... эхийгээ Алан-гуаг үгүй болсны хойно ах нар, дүү нар тавуул адуусан идээгээ хуваалдруун...]

"&146... bi ya'araju urit ire'esü tayici'ut noyat minu qocoruqsan eme kö'ün adu'un ide'en-i minu hünesü-ēr geyisgekün tede ke'ejü..."(1-66) [би яарч урьд ирвээс тайчууд ноёд, миний хоцорсон эм хөвүүн адуун идээнийг минь үнэсээр хийсгэх, тэд хэмээж...]

"&153...altan qucar dāritai qurban üges-tür ülü gürün olja-tur bayijju'ui üges-tür ese gürba ke'en jebe qubilai qoyar-i ilējü oljalaqsat adu'un ya'u ke abuqsat-i bügüde-yi abqa'ulba (1-71) [Алтан Хучар Дааритай гурван үгст үл хүрэн, олзонд байжээ. Үгст эс хүрэв хэмээн Зэв, Хубилай хоёрыг илгээж олзолсон адуун юу хэ (юм хүм) авсныг бүгдийг авхуулав]

"&272...irgen orqa altan mönggün adu'usun ide'en joli'a ökgüye ke'en abitla'asu ülü talbiran dület türgün-e adalamui" (1-164) [иргэн орга, алтан мөнгөн, адуус идээн золио өгье хэмээн авидлаваас үл талбиран дүлэд түргэнээ адламуй]

Дээрх жишээнд гарч байгаа "adu'usun ide'en" (адуус идээн), "adu'un ide'en" (адуун идээн) гэдэг нь хэвшмэл үг байсан бөгөөд мал хөрөнгө, бүх эд хогшил гэсэн утгатай ажээ. Адуу гэсэн нэр үгээс үүссэн адуулах гэдэг үйл үг дундад үеийн монгол хэл, тухайлбал "МНТ"-нд их идэвхтэй хэрэглэгдэж, орчин цагийн монгол хэлний "маллах, хариулах"-ын утгыг илтгэж байжээ. "МНТ"-нд маллах гэсэн үүсмэл үйл үг байтугай мал гэдэг нэр үг нь ч үл тохиолдоно. Тэр бүү хэл, 17-р зууны сурвалж Лу "Алтан товч"-д хоёрхон удаа мал гэж гарах бөгөөд эртний түрэг хэлэнд

мал гэвэл хөрөнгө зөөр, эд агуурс гэсэн утгатай (36-335) бөгөөд "Мукаддимат-ал-адаб" толь бичигт "malun ejen ere" [малын эзэн эр] гэж тэмдэглээд "хөрөнгийн эзэн эр" [хозяин имущества мужчина] (37-233) гэж орчуулсныг үзэхэд, дундад үеийн монгол хэлний өрнөд аялгуунд эртний түрэг хэлтэй адил утгаар хэрэглэж байжээ.

"Хариулах" гэдэг үг "МНТ"-нд 11 удаа тохиолдох боловч хариу барих, буцаан эгүүлэх гэсэн утгаар л хэрэглэгджээ. Энэ хоёр зүйлийн утгын цаана "qariγu+la+qu", "qari+γul+qu" гэсэн хоёр өөр бүтэц бий билээ. Бэлчээрт яваа малыг хотонд нь буцаан ирүүлэх гэсэн явцуу утгаар хариулах гэж хэлж ярьдаг байснаа, орчин цагийн монгол хэлэнд маллах, бэлчээрлүүлэх гэсэн өргөн утгатай болжээ. Дундад үеийн монгол хэлэнд аль ч мал маллахыг ялгалгүй "адуулах" гэж ярьдаг байсныг "МНТ"-нд тохиолдох "тэмээ адуулах" (1-70), "хонь адуулах" (1-52) гэх мэтийн жишээ нутлах билээ.

Агт, морь, адуу гэсэн гурван үг дундад үеийн монгол хэлэнд илэрхийлэх утга, хэрэглэгдэх хүрээ, үгийн найруулгын өнгө зэрэг нь ямар байсан, орчин цагийн монгол хэлнийхээс юугаараа ялгаатай байв гэдгийг товчхон өгүүлэхэд ийм байна. Агт, морь, адууны тухай өмнө өгүүлсэн баримтаа түшиж, "МНТ"-ны "шарга агттан найман морьд" гэсэн үг хэллэгийг шинжлэхэд, дундад үеийн монгол хэлэнд агт, морь гэсэн хоёр үг нь өөр өөрийн утга хэрэглээ бүхий жинхэнэ нэр байсан тул "агттан" нь "морьд"-ын тодотгол болж, тэмдэг нэрийн үүргээр орсон байх боломжгүй юм.

Товч дүгнэлт

1. Дундад үеийн монгол хэлэнд утга үүрэг, хэлзүйн хэлбэр, хэрэглэгдэх хүрээ хэмжээ, улирч хувьссан байдал, гарал үүсэл зэргээрээ ялгаатай хоёр зүйлийн "-tan" хэмээх дагавар байжээ гэдгийг судлан гаргав.
2. "МНТ"-нд тохиолдох "sirqa aqta-tan" [шарга агттан] хэмээх үгэнд дундад үеийн монгол хэлний товчлон хураах, хүндэтгэх утгатай "-tan" дагавар залгасан болохыг тодлов.
3. "МНТ"-ны "sirqa aqta-tan naiman morit" [шарга агттан найман морьд] гэсэн үг хэллэгийг судлаачид хэрхэн үзэж орчуулсныг харьцуулан үзэж, өөрийн бодлыг өгүүлэв.
4. "МНТ"-ны хэлэнд агт, морь, адуу гэсэн үгс ямар ялгамжтай байсныг баримтаар нягтлав.
5. 17-р зууны эхэн үеэс өнөө хүртэлх түүх, уран зохиолын нэн арвин зохиол бүтээлд "Чингисийн найман шарга" хэмээн бичиж ирснийг эх бичгийн баримтаар няцааж, нэг онгон шарга агт бүхий найман морь байсныг батлахыг хичээв.

НОМЗҮЙ

1. **Rachewiltz Igor de**, *"Index to the secret history of the mongols"*, Bloomington, 1972.
2. ***"Алтан товч"*** (Лувсанданзаны "Алтан товч"-ийн эх бичгийн хуулбар), Улаанбаатар, 1990.
3. **Damdinsürüng Ce**, *"Mongγol uran ǰokiyal-un degeǰi ǰayun bilig orosibai"*, I боть, Köke qota, 1982.
4. **Рашид-ад-дин**, *"Судрын чуулган"*, I боть, I дэвтэр, Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо, Улаанбаатар, 1994.
5. **Козин С.А**, *"Сокровенное сказание монголов"*, Перевод С.А.Козина, Улан-Удэ, 1990.
6. **Cleaves F.W**, *"The Secret History of the Mongols"*, Tranlated and edited by F.W.Cleaves, London, 1982.
7. **Pelliot P**, *"Histoire secréts des Mongols"*, Paris, 1949.
8. *"Geheime Geschichte der Mongolen"* hrsg. von Manfred Taube, Leipzig und Weimar, 1989.
9. **Bayar**, *"Mongγol-un niγuča tobčayan "*, I debter, Kökeqota, 1980.
10. *"Kitad mongγol toli"*, Kökeqota, 1996.
11. **Ahmet Temir**, *"Moğollarin girli tarihi"*, (Yazilişi: 1240), Ankara, 1995.
12. *"Die geheime Geschichte der Mongolen"* hrsg. von Walther Heissig, Düsseldorf. Köln, 1981.
13. **Stanislaw Kaluzynski**, *Tajna historia mongolöw*, Warszawa, 1970.
14. **Shigeo Ozawa**, *"Genchō-hishi zenshaku"* (МНТ-ны бүрэн тайлбар), II боть, Токио, 1985.
15. **Рамстедт Г.И**, *"Введение в алтайское языкознание"*, Москва, 1957.
16. **Орловская М.Н**, *"Язык "Алтан тобчи"*, Москва, 1984.
17. **ǰaγunnasutu**, *"bá sái bá zì hè měng gu yu wen xiàn"*, II wen xiàn huì jì, ("Пагва үсэг хийгээд монгол хэлний дурсгалууд", II дурсгал бичгийн эмхтгэл) Tokyo, 1991.
18. **Bousiyang**, *"mongγol üsüg bičig-ün uqaγan"*, Köke qota, 1984.
19. **Baatar M**, *"Dumdadu ǰayun-u mongγol kelen-ü "tan" kelberi-yin tuqai"*, Mongγol kele bičig sedkül, 1989 (№133), 30-35.
20. **Yu-čian**, *"mongγol-un niγuča tobciyan"-u kelen deki daγaburi üge-yin tuqai"*, "öbür mongγol-un neyigem-ün sinǰilekü uqaγan" sedkül, 2001, №1 (№110), 55-62.
21. **Cleaves F.W**, *"The lingǰi of Aruγ of 1340"*, HJAS, 25 (1964-1965), 31-78.
22. **Лувсанбалдан Х**, *"Аруг вангийн хөшөөний бичиг"*, Studia Mongolica-IV, Улаанбаатар, 1962, 123-137.
23. **Bulaγ B**, *"mongγol üsüg bičig-ün tobča teüke"*, Köke qota, 1983.
24. **Дамдинсүрэн Ц**, *"Монголын нууц товчоо"*, Дөрөв дэх хэвлэл, Улаанбаатар, 1990.
25. **Цэрэнсодном Д**, *"Монголын нууц товчоо"*, Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, Улаанбаатар, 2000.

26. *"qua-i-i-yu"*, sin-e-ber kinan emkidkejü γaliγlaju, tayilburi kigsen O.Mandaqu, Köke qota, 1998.
27. **Төмөртогоо Д**, *"Монгол хэлний түүхэн хэлзүйн үндэс"*, I дэвтэр, Улаанбаатар, 1992.
28. **Sečenčoγtu**, *"Mongγol üges-ün iǰaγur-un toli"*, Köke qota, 1988.
29. **Дулам С**, *"Монгол бэлгэдэл зүй"*, дэд дэвтэр (Өнгөний бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй), Улаанбаатар, 2000.
30. **Далай Ч**, *"Монголын түүх"* (Их Монгол улс 1206-1260), дэд дэвтэр, Улаанбаатар, 1994.
31. **Далай Ч**, *"Монголын бөө мөргөлийн товч түүх"*, Улаанбаатар, 1959.
32. **Жиованни Дель Плано Карпини**, *"Монголчуудын түүх"*, Орос хэлнээс орчуулсан С.Туяа, С.Цолмон, Улаанбаатар, 1988.
33. **Нацагдорж Ш**, *"Чингис хааны цадиг"*, Улаанбаатар, 1991.
34. *"Qorin nigetü-yin tayilburi toli"*, Köke qota, 1979.
35. **Даль В**, *"Толковый словарь живаго Великорусскаго языка"*, Москва, 1881 /М. Ря. 1981 т.II/
36. *"Древнетюркский словарь"*, Ленинград, 1969.
37. **Поппе Н.Н**, *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб*, Москва-Ленинград, 1938.